

**Олон улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны хэрэгжилтийг сайжруулах нь**

2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр, Франц улс, Парис хот.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) стандартын хэрэгжилтийг хянах хүрээнд Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (Financial Action Task Force буюу ФАТФ) нь дараах улсуудыг МУТСТ стратегийн дутагдалтай байна хэмээн үзэж түүнийг засч залруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтран боловсруулаад байна. Улс орон бүрийн хувьд нөхцөл байдал харилцан адилгүй ч илэрсэн дутагдлаа засаж сайжруулах улс төрийн өндөр түвшний хүсэл зоригоо бичгээр илэрхийлснийг ФАТФ-ын зүгээс сайшаан дэмжиж байна.

ФАТФ-аас цаашид үнэлж дүгнэх нэлээдгүй улс орон байгаа бөгөөд олон улсын санхүүгийн системд эрсдэл учруулж буй улс орныг тогтоох ажлаа үргэлжлүүлэх болно. ФАТФ болон ФАТФ-ын төрлийн бүс нутгийн байгууллагууд дор дурдсан улс орнуудтай хамтран ажиллаж, илрүүлсэн дутагдал, засаж сайжруулах ажлыг тайлагнах болно. ФАТФ-ын зүгээс эдгээр улс оронд хандан үйл ажиллагааны төлөвлөгөөгөө хугацаанд нь шуурхай хэрэгжүүлэхийг уриалахын сацуу төлөвлөгөөний хэрэгжилтийг анхааралтай хянана гэдгээ мэдэгдэж байна. ФАТФ-ын зүгээс гишүүддээ хандан эдгээр улс орны хувьд харилцагчдыг таньж мэдэх өргөжүүлсэн үйл ажиллагаа явуулахыг шаардахгүй ч эрсдэлийн шинжилгээндээ дор дурдсан мэдээллийг харгалзан үзэхийг мэдэгдэж байна.

**Монгол Улс**

Монгол Улс 2019 оны 10 дугаар сард МУТСТ тогтолцоогоо боловсронгуй болгох чиглэлээр ФАТФ болон Ази, Номхон далайн бүсийн байгууллагатай хамтран ажиллах улс төрийн өндөр түвшний эрмэлзлийг илэрхийлсэн болно.

2017 оноос хойш Монгол Улс харилцан үнэлгээний тайланд өгсөн техникийн хэрэгжилт, үр дүнтэй байдлыг дээшлүүлэх зөвлөмжийг хэрэгжүүлэхэд ахиц дэвшил гаргасан байна. Тухайлбал, холбогдох хууль, тогтоомж журмыг шинэчилснээр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн талаарх ойлголтоо сайжруулж, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой хориг арга хэмжээг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн болон институцийн тогтолцоог нэвтрүүлсэн байна.

Монгол Улс цаашид үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллахдаа дараах арга хэмжээг авна: (1) Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч (СББМҮҮ)-ийг хянан шалгах байгууллагын тухайн салбарын МУТС эрсдэлийн талаарх ойлголтыг сайжруулах, хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан аргачлалаар хийж гүйцэтгэх, МУТСТ үүргээ зөрчсөн тохиолдолд гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн арга хэмжээ авах; (2) мөнгө угаах үйлдлийг тогтоосон эрсдэлтэй нь нийцүүлэн мөрдөн шалгах, яллах ажиллагааг нэмэгдүүлэх; (3) хилээр мэдүүлээгүй/худал мэдүүлсэн мөнгөн тэмдэгтийг хураан авах, битүүмжлэх үйл ажиллагааг үргэлжлүүлэх, гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн арга хэмжээ авах; (4) хориг арга хэмжээг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр эрх бүхий байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагааг хангах; санхүүгийн байгууллага, СББМҮҮ-дийн зүгээс үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой хориг арга хэмжээг хэрэгжүүлж буйд хяналт тавих, гаргасан зөрчилд нь дүйцэхүйц дахин үйлдэхээс сэргийлсэн арга хэмжээ авах.